

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
 хот

**ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ
ТУХАЙ ХУУЛЬ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол улс дотоодын түүхий эдэд түшиглэн газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж, нефть-химийн шинэ салбарыг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Газрын тос боловсруулах үйлдвэрийг
дэмжих хууль тогтоомж**

2.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Барилгын тухай хууль, Усны тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол улсын Олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар зөвхөн төрөөс хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах болон түүхий тос дамжуулах хоолой барих төсөл, тэдгээрийн технологийн үндсэн ба дагалдах, туслах байгууламжийг барьж, ашиглалтад оруулах, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүйгээр зохион байгуулахад чиглэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2. Энэ хуулиар зохицуулаагүй газрын тосны үйлдвэртэй холбогдсон харилцааг холбогдох бусад хуулиар зохицуулна.

3.3. Энэ хуульд заасан харилцааг нарийвчлан зохицуулах “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих төрөөс үзүүлэх үйлчилгээг хялбаршуулсан горим”-ын тухай журмыг Засгийн газар батална.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРТ
ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ**

4 дүгээр зүйл. Төрөөс үзүүлэх дэмжлэг

4.1. Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дараах дэмжлэгийг үзүүлнэ.

4.1.1. газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламж барих үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

4.1.2. бүтээн байгуулалтанд оролцох ажиллах хүч, мэргэжилтэн гадаадаас авах, холбогдох зөвшөөрлийг шуурхай олгох асуудлыг энэ хуулийн 3.3-д заасан журмаар зохицуулах;

4.1.3. газрын доорх усны нөөцөд улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын доорх усны нөөцийн эрэл, хайгуул, судалгааны зардлыг ус ашиглагчаар эргүүлэн төлүүлэх төлбөрөөс чөлөөлөх;

4.1.4. газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийн барилга угсралтанд шаардлагатай машин механизм, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, түүхий эд, бараа материалын тээвэрлэлтийг хөнгөвчлөх харилцааг энэ хуулийн 3.3-д заасан журмаар зохицуулах;

4.1.5. "газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн аюулгүй байдал, харуул хамгаалалтыг зохион байгуулах" харилцааг энэ хуулийн 3.3-д заасан журмаар зохицуулах;

**5 дугаар зүйл. Газрын тос боловсруулах үйлдвэр болон
түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн
үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийн
барилгын үйл ажиллагаа**

5.1. Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийн зураг төслийг гэрээнд заасан хэлээр боловсруулах, баталгаажуулах, зураг төсөлд магадлал хийх, барилгын ажилд хяналт тавих, ашиглалтад хүлээн авах харилцааг энэ хуулийн 3.3-т заасан журмаар зохицуулна.

5.2. Улсын чанартай, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийн зураг төслийг боловсруулах, баталгаажуулах болон барилгын ажилд олон улсын норм, дүрэм, журам, стандартыг гэрээнд заасан хэлээр хэрэглэнэ.

5.3. Барилгын тухай хуулийн 6.3-т заасны дагуу энэ хуулийн 5.2-т заасан олон улсын норм, дүрэм, стандартыг гэрээнд заасан хэлээр бүртгэх, хэрэглэх харилцааг энэ хуулийн 3.3-т заасан журмаар зохицуулна.

ТӨСӨЛ

5.4. Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн технологийн ба дагалдах, туслах байгууламжийн барилгын ажлын зөвшөөрөл олгох асуудлыг Барилгын тухай хуулийн 32.1.5 дахь заалтыг үндэслэн энэ хуулийн 3.3-т заасан журмаар зохицуулна.

6 дугаар зүйл. Газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэрийн газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа

6.1. Газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэр нь түүхий эдийн хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж болно.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талбай олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

6.3. Газрын тос хайх, ашиглах үйл ажиллагааг гадаад, дотоодын аж ахуйн нэгжтэй хамтран явуулж болох бөгөөд Засгийн газраас эрх олгосны үндсэн дээр гэрээ байгуулна.

6.4. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын шийдвэрээр олгогдсон талбайд өмнө хийгдсэн геологи, геофизик, гидрогоеологи, геохими, өрөмдлөг зэрэг хайгуулын ажлын анхдагч болон боловсруулалт хийгдсэн тайлан, материал, мэдээллийг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит компанид үнэ төлбөргүй өгнө.

7 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

7.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ГАРЫН ҮСЭГ